

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН
АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ТУХАЙ

2023.00.00

Улаанбаатар хот

6

Нэхэмжлэгч: Оршин суугаа газрын хаяг, ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, утасны дугаар

Хариуцагч: Оршин суугаа газрын хаяг, ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, утасны дугаар

Нэхэмжлэлийн шаардлага: 2.166.840 төгрөгийг гаргуулах тухай

Би 2021 оны 00 сарын 00-нд иргэн Батад Солонгосын виз гаргуулхаар 5.000.000 төгрөгийг түүний Хас банкны 0000000000 тоот дансанд шилжүүлэн өгсөн. Бат 2 сарын дотор Солонгосын виз гаргуулж өгнө гэсэн тул миний бие өөрийн гадаад паспортыг түүнд өгсөн. Түүнээс хойш 2 сар болсон ч сураггүй байсан тул миний бие түүний гар утсаар холбогдож виза гарсан эсэхийг лавлахад ...Арай гараагүй байна, ирэх долоо хоногийн 5 дахь өдөр гарна, түр хүлээж бай... зэрэг хариу өгч байсан ч сүүлдээ утас нь холбогдохгүй болсон.

Миний бие түүний гэрийн хаягаар удаа дараа очиж уулзан ...Виза гарсан уу, гарахгүй бол мөнгөө авъя... гэхэд Бат ...Чиний мөнгийг Солонгос элчин ажилладаг найздаа өгсөн, жаахан хүлээж бай, ...мөнгө, паспортаа буцааж авъя... гэхэд мөнгийг чинь одоо өгөх боломжгүй байна. Би Солонгос элчин ажилладаг найздаа чиний мөнгийг өгсөн. Түүнээс аваад өгье... зэргээр худал, үнэн хэлсээр өдий хүрсэн. Сүүлдээ ...Паспортаа ав гэхэд би паспортаа авч, 5.000.000 төгрөгийг 7 хоногын дотор өгнө гэсэн бичгийг Батаар хийлгэн авч, гарын үсгийг нь зуруулсан.

Түүнээс хойш 1 сар өнгөрөхөд миний мөнгийг өгөхгүй, гэрээр нь очиход хаалга нь түгжээтэй уулзаж чадахгүй байдалд хүрээд байна.

Иймд хариуцагч Батаас 5.000.000 төгрөгийг гаргуулж өгнө үү.

Нэхэмжлэлд хавсаргасан баримтын жагсаалт:

- 1.Нэхэмжлэл /2 хувь/
- 2.Нэхэмжлэгчийн иргэний үнэмлэхийн хуулбар нотариатчаар гэрчлүүлсэн
- 3.Мөнгө шилжүүлсэн баримт
- 4.Иргэн Доржийн бичгээр үйлдсэн баталгаа
5. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт

Улсын тэмдэгтийн хураамжийг Татварын ерөнхий газрын itax.mta.mn сайтаас төлбөрийн даалгавар үүсгэж, дурын банкны салбарт тушаах эсхүл шүүхийн байранд байршуулсан Gegece системийн өөртөө үйлчлэх төхөөрөмжөөр банкны карт ашиглан төлөх боломжтой.



Нэхэмжлэл гаргасан:

Нэр, гарын үсэг